

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
САХБАМО	Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд
ҮЦТХТ	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УУХҮЯ	Уул уурхай хүнд үйлдвэрийн яам
ХХК	Хязгаарлагдмал хувьцаат Компани
ХК	Хувьцаат компани

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	4
2	Аудитын тайлан.....	6
2.1.	Оршил	6
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	6
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	7
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	7
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	10
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	11
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	11
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	12
2.8.1	Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл.....	12
2.8.2	Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал	13
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	13
2.10.	Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	16
2.11.	Шилэн дансны мэдээлэл.....	17
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	17
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	17
3	Менежментийн захидал	18
3.1	НӨАТ-ын ногдуулалттай холбоотой асуудал.....	18
3.1.1	Илрүүлэлт:	18
3.1.2	Эрсдэл:.....	19
3.1.3	Өгсөн зөвлөмж:	19
3.1.4	Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:.....	19
3.2	Шатахууны зарцуулалттай холбоотой асуудал	19
3.2.1	Илрүүлэлт:	19
3.2.2	Эрсдэл:.....	19
3.2.3	Өгсөн зөвлөмж:	19
3.2.4	Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:.....	19
3.3	Автомашинны ашиглалттын тухай	20
3.3.1	Илрүүлэлт:	20
3.3.2	Эрсдэл:.....	20

3.3.3 Өгсөн зөвлөмж:	20
3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:	20
3.4 Дуудлага худалдааны тухай	20
3.4.1. Илрүүлэлт:	20
3.4.2 Эрсдэл:	20
3.4.3 Өгсөн зөвлөмж:	20
3.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:	21
4 Аудит хийсэн санхүүгийн тайлан	22
4.4.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан	22
4.2 Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан	24
4.3 Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан	26
4.4 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан	27
5. Хавсралт	29
5.1 Аудиитоор илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл	29



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

“ЭРДЭНЭС МОНГОЛ” ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ П.ГАНХҮҮ
ТАНАА

2019.03.15 № 06/494
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Эрдэнэс Монгол” ХХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Эрдэнэс Монгол ХХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Эрдэнэс Монгол” ХХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

“Эрдэнэс Монгол” ХХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

“Эрдэнэс Монгол” ХХК-ийн 2018 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүн, дүгнэлтийг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал П.Ганхүү танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Эрдэнэс Монгол” ХХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

“Эрдэнэс Монгол” ХХК-ийн 2018 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт гаргах нь энэхүү аудитын зорилт байв.

“Эрдэнэс Монгол” ХХК-ийн удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 12 дугаар сарын 25-аас 2019 оны 3 дугаар сарын 12-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 3 сарын 15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, “Эйч Эл Би Монголиа Аудит” ХХК-ийн ахлах аудитор

Л.Сарантуяа, аудитор Б.Цэрэндэлгэр, аудиторын туслах М.Нямсүрэн, Б.Ганчимэг нар хариуцаж хэрэгжүүлэв.

“Эрдэнэс Монгол” ХХК-ийн 2018 оны санхүүгийн тайланг “Эйч Эл Би Монголиа Аудит” ХХК-д 2019 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 16/137 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС, СТОУС, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

"Эрдэнэс Монгол" ХХК-ийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Монгол Улсын байгалийн нөөцийг үр ашигтай ашиглаж, уул уурхай, дэд бүтэц, эрчим хүчний салбарт урт хугацааны хөрөнгө оруулалт хийх, бизнесийн үнэ цэнийг нэмэгдүүлж, хувьцаа эзэмшигч иргэдэд бодит үр ашгийг хүртээх, эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах үндэсний хөрөнгө оруулалтын компани болно гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилгоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

"Эрдэнэс Монгол" ХХК-ийн дүрэмд байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

➤ **Төрийн төлөөллийг хэрэгжүүлэх талаар:**

- САХБАМО-ын төрийн эзэмшлийн хувьцаа эзэмших эрх эдлэх
- Төрийн эзэмшлийн хувьцааны ногдол ашиг, хувьцаа борлуулсны орлого
- САХБАМО-ыг ашиглах урьдчилгааны орлогыг төвлөрүүлэх
- Төрийн эзэмшлийн хувьцааны ногдол ашгийн хувь хэмжээг нэмэгдүүлэх

➤ **Стратегийн ордын ашиглалтын талаар:**

- Ашигт малтмын геологийн судалгааны хайгуулын ажил гүйцэтгэх
- САХБАМО-ын нөөц, хил хязгаарыг тогтоох аргачлал, зарчмыг боловсруулан эрх бүхий эрх бүхий байгууллагаар батлуулах
- Ордыг дангаараа болон бусад этгээдтэй хамтран ашиглах
- Ашигт малтмалыг олборлох, боловсруулах үйлдвэр байгуулах
- Дэд бүтцийн төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх
- Нөөцийн хуваарилалт, тээвэр, агуулах, гаалийн хяналтын бүсийн үйлчилгээ
- Ашигт малтмалыг боловсруулах, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх

➤ **Тусгай зөвшөөрөл, эд хөрөнгө эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаар:**

- САХБАМО-ын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмших, шилжүүлэх, барьцаалах
- САХБАМО-ын тусгай зөвшөөрлийн шилжилт хөдөлгөөнд хяналт тавих, тооллогыг зохион байгуулах
- Эд хөрөнгө, тоног төхөөрөмж болон оюуны өмчийн эрхийг эзэмших, ашиглах, түрээслэх, худалдах

➤ **Санхүүжилтийн эх үүсвэр олох, хуваарилах талаар:**

- САХБАМО-ын ашиглалтын чиглэлээр IPO, PP хийх замаар хөрөнгө оруулалтыг татах
- Эрх бүхий байгууллагын шийдвэрээр өрийн бичиг /бонд/ гаргах, хувьцааг нь эзэмшдэг хуулийн этгээдэд зээл олгох

- Ашигт малтмалын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа төрийн өмчийн оролцоотой компаниудын төрийн эзэмшлийн хувьцааг худалдах, стратегийн хөрөнгө оруулагчийг татан оролцуулах

➤ **Зөвлөх үйлчилгээ үзүүлэх талаар:**

- Маркетингийн бодлого, дунд, урт хугацааны төлөвлөгөө боловсруулах, хэрэгжилтийг хангах
- ТЭЗҮ, нөөцийн үнэлгээ, хөрөнгө, санхүүгийн төлөвлөлт хийх
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх
- САХБАМО-ын мэдээллийг дотоод, гадаадад сурталчлах, олон нийттэй харилцах ажлыг зохион байгуулах

"Эрдэнэс Монгол" ХХК-ийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

"Эрдэнэс Монгол" ХХК-ийн удирдлага Сангийн сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

Монгол Улсын хуулиуд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Ашигт малтмалын тухай хууль
- Цөмийн энергийн тухай хууль
- Хөрөнгө оруулалтын тухай хууль

Улсын Их Хурлын тогтоолууд:

- Тодорхой ордыг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамааруулах тухай 2007 он №27
- Оюу толгой ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээний тухай 2009 он №57
- Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого батлах тухай 2010 он №39
- Таван толгойн нүүрсний ордыг ашиглах зарим асуудлын тухай 2014 он №18

Засгийн газрын тогтоолууд:

- Төрийн өмчит хуулийн этгээд байгуулах тухай 2006 он №266
- “Эрдэнэс-таван толгой” ХК байгуулах тухай 2010 он №372
- Монгол Улсын иргэнд “Эрдэнэс-таван толгой” ХК-ийн хувьцааг эзэмшүүлэх тухай 2011 он №98
- “Эрдэнэс-Оюутолгой” ХХК байгуулах тухай 2011 он №348
- “Эрдэнэс-тавантолгой” ХК-ийн хувьцааг иргэдэд эзэмшүүлэх аж ахуйн нэгжид худалдахтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2012 он №116
- Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах ажлыг эрчимжүүлэх талаар авах арга хэмжээний тухай 2013 он №100
- Журам батлах тухай /хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах журам/ 2014он №52
- Эрдэнэс Монгол ХХК болон түүний охин компанийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2017 он №174
- Эрдэнэс Таван толгой ХХК-ийн талаар авах арга хэмжээний тухай 2018 он №245

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Засгийн газрын 2018 оны 245 тоот тогтоолын 4 дүгээр заалтаар “Эрдэнэс Таван толгой” ХХК байгуулах тухай Засгийн газрын 2010 оны 272 дугаар тогтоолын нэгдүгээр зүйлийн “Эрдэнэс Монгол ХХК-ийн охин компанийн хэлбэрээр” гэсэн хэсэг хасагдсан.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

“Эрдэнэс Монгол” ХХК нь 2017 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн Төлөөлөн Удирдах зөвлөлийн 45 тоот тогтоолоор Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулж 2018 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдөж эхэлсэн бөгөөд энэ нь Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

“Эрдэнэс Монгол” ХХК-ийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагааг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

“Эрдэнэс Монгол” ХХК-ийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Винница” програм хангамж ашигладаг байна.

“Эрдэнэс Монгол” ХХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт Үр нөлөөгүй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад “Эрдэнэс Монгол” ХХК-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 11 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 10 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Үйл ажиллагааны орлогыг сонгов.

Энэ нь санхүүгийн тайлангийн нийт хөрөнгө, цэвэр хөрөнгийн үзүүлэлтүүд нь хэт өндөр дүнтэй байгаатай холбоотой юм.

“Эрдэнэс Монгол” ХХК-ийн 2018 оны жилийн эцсийн нийт орлого нь 72,673.4 сая төгрөг бөгөөд түүний 1.5 хувь болох 1,090.1 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1.5 хувиар тооцсон нь дундаж эрсдэлтэй гэж үзсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 16 чиглэлээр аудитын 16 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 10 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 2 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 4 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

2.8.1 Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах асуудлыг залруулан санхүүгийн тайланд тусгаж, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн удирдлагаар зөвшөөрүүлэн баталгаажуулав. Үүнд:

- Хөгжлийн банкнаас авсан урт хугацаат зээлийн нэг жилийн дотор буюу 2019 онд төлөх хэсэг 85,297.7 сая төгрөгийг богино хугацаат өглөг хэсэгт шилжүүлэн бүртгээгүй
- “Санхүү болон орлогын албан татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах журам”-ын дагуу Татварын болон санхүүгийн тайлангийн зорилгоор байгуулсан үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлын зөрүү 75.2 сая төгрөгийг санхүүгийн тайлан, Санхүү болон орлогын албан татварын тайлангийн хоорондын зөрүүг зохицуулах тайланд тусгаагүй
- Таван толгой - Гашуун сухайт чиглэлийн 155,962,1 сая төгрөгийн өртөгтэй авто замыг эзэмших эрхтэй гэсэн үндэслэлээр санхүүгийн тайланд биет бус хөрөнгөөр буруу ангилж бүртгэснийг залруулж үндсэн хөрөнгөд шилжүүлэн бүртгэв.
- 11,655,9 сая төгрөгийн өртөг бүхий Гашуун сухайтын боомт, болон боомтын байгууламжийг өөрийн үйл ажиллагаанд ашигладаггүй үндэслэлээр Борлуулахад бэлэн эргэлтийн бус хөрөнгөөр буруу ангилан бүртгэсэн байсныг үндсэн хөрөнгийн ангилалд шилжүүлэн бүртгэв.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

2.8.2 Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(Сая төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	4	271.8	
2	Төлбөрийн акт тогтоосон	0		
3	Албан шаардлага өгсөн	0		
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0		
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0		
	Дүн	4	271.8	

2.8.2.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, шаардлагатай залруулгыг санхүүгийн тайланд хийлгэлээ.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Нэг. Засгийн газрын 2018 оны 245 тоот тогтоолын хэрэгжилтийн талаар.

2018 оны 8-р сарын 8-ны өдөр “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 245 дугаар тогтоол гарсан бөгөөд энэ тогтоолоор дараахь шийдвэрүүд гарсан байна. Үүнд:

1. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн төрийн мэдлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч этгээдээр УУХҮЯ болон ТӨБЗГ-ыг тус тус томилж, ТӨБЗГ-т хувьцаа эзэмшигчийн эрх хэрэгжүүлэгч этгээдийн бүртгэлд өөрчлөлт оруулахыг даалгасан байна.
2. “Эрдэнэс Таван толгой” ХК байгуулах тухай Засгийн газрын 2010 оны 272 тоот тогтоолын 1 дүгээр зүйлийн “Эрдэнэс Монгол” ХХК-ийн охин компани хэлбэрээр байгуулна гэсэн хэсгийг хүчингүй болгосон.

3. Засгийн газрын 2016 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”д өөрчлөлт оруулж “Эрдэнэс Монгол” ХХК-ийн “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн төрийн өмчийн төлөөллийн эрхийг хүчингүй болгосон.

Засгийн газрын энэ тогтоолын дагуу “Эрдэнэс Монгол” ХХК-ийн эзэмшиж буй “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн төрийн өмчийн хувьцааны 65.2 хувийн хувьцааг шилжүүлж санхүүгийн тайлангийн бүртгэлд өөрчлөлт оруулснаар “Эрдэнэс Монгол” ХХК-ийн хувьд дараахь сөрөг үр дагавар үүсэхээр байна. Үүнд:

- “Эрдэнэс Монгол” ХХК-ийн нийт хөрөнгийн дүн 9,125,403.4 сая төгрөгөөр буюу 97%-иар буурч “Эрдэнэс Монгол” ХХК-ийн санхүүгийн чадавхийн үзүүлэлт илт буурсан үр дүн гарахаар байна
- 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгагдсан Азийн хөгжлийн банк, Хөгжлийн банкнаас авсан нийт 170,615,4 сая төгрөгийн урт хугацаат зээлийг эргэн төлөх чадварт сөргөөр нөлөөлнө.
- “Эрдэнэс Таван толгой” ХК-аас жил бүр авч байсан 6-10 тэрбум төгрөгийн менежментийн төлбөрийн орлого байхгүй болж цэвэр ашгийн хэмжээ энэ дүнгээр буурна;
- Бусад охин болон хараат компани болох “Эрдэнэс Метан” ХХК, “Мон-Атом” ХХК, “Эрдэнэс Алт ресурс” ХХК, “Эрдэнэс Шивээ Энержи” ХХК, “Шивээ энержи” төсөл, “Эрдэнэс Оюу толгой” ХХК-уудын үйл ажиллагаанд зориулан зээл хэлбэрээр өгч буй санхүүжилтийг үргэлжлүүлэн олгох боломж буурна.
- Ирээдүйд ашигтай бусад төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх, хөрөнгө оруулалт татах, өрийн бичиг гаргах, зээл авахад компанийн хөрөнгийн хэмжээ, санхүүгийн чадамж хангалтгүй хэмжээнд хүрэх нөхцөл байдал үүсэхээр байна.

Нөгөө талаас өнөөдрийн байдлаар ҮЦТХТ-д байгаа “Эрдэнэс Тавантолгой” ХК болон “Эрдэнэс Монгол” ХХК-уудын хувьцааны бүртгэлд Засгийн газрын 2018 оны 245 тоот тогтоолын дагуу хувьцаа эзэмшигчийн бүртгэлд ямар нэгэн өөрчлөлт хийгдээгүй байна.

Дээр дурдсан нөхцөл байдлуудын улмаас бид “Эрдэнэс Монгол” ХХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Засгийн газрын 2018 оны 245 дугаар тогтоолын дагуу “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааны бүртгэлтэй уялдуулан залруулах бичилт хийх нөхцөл бүрэлдээгүй байна гэж үзсэн болно.

Хоёр. Урт хугацаат зээлийг эргэн төлөх эх үүсвэрийн талаар

Тавантолгой-Гашуунсухайи чиглэлийн хүнд даацын, тусгай зориулалтын 239 км авто зам, Гашуунсухайт боомтын хүчин чадлыг нэмэгдүүлэх зориулалт бүхий дэд бүтцийг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн мэдэлд шилжүүлсэнтэй холбоотойгоор тус компанид 2014 онд

Хөгжлийн банкнаас олгосон 170,615,4 сая төгрөгийн урт хугацаат зээлийн хүүний төлбөрийг графикайн дагуу тухай бүр төлж ирсэн байна. Уг зээлийн үндсэн төлбөрийг 2019-2020 онд тэнцүү хэмжээгээр эргэн төлөх нөхцлийн дагуу 2019 онд зээлийн үндсэн төлбөрт 85,297.7 сая төгрөг төлөхөөр зээлийн гэрээний хавсралтад тусгагдсан байна. Гэтэл “Эрдэнэс Монгол” ХХК-ийн үндсэн орлого болох Гашуун сухайтын авто зам ашигласны төлбөр, охин компаниудаас авч байгаа менежментийн гэрээний төлбөр зэргээс бүрэлдэх нийт орлогын өнгөрсөн жилүүдийн дундаж дүн нь 50-70 тэрбум төгрөг байгаагаас харахад дээр дурдсан урт хугацаат зээлийг 2019-2020 онд төлж барагдуулах орлогын эх үүсвэр хангалтгүй гэж дүгнэхээр байна. Энэ нөхцөл байдлын улмаас “Монгол Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилтийг хангах тухай” Засгийн Газрын 2017 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн 42 тоот тогтоолоор зээлийн үндсэн төлбөрийг 2019-2020 онд тэнцүү хэмжээтэйгээр төлөх нөхцлийг өөрчлөн тухайн төслийн буюу Гашуун сухайтын авто замын орлоготой уялдуулан эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлд шилжүүлж, холбогдох гэрээг Хөгжлийн банк, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн хооронд шинэчлэн байгуулахыг Хөгжлийн банкны удирдах зөвлөл болон “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захиралд даалгасан байна. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор “Эрдэнэс Монгол” ХХК-ийн зүгээс зээлийг эргэн төлөх 2 замыг санал болгож, Хөгжлийн банкны удирдлага, Төлөөлөн Удирдах Зөвлөлд албан тоотоор хүргүүлсэн байна. Үүнд:

1. Зээлийн өрөнд тооцон өөрийн эзэмшлийн “Эрдэнэс Таван Толгой” ХК-ийн төрийн мэдлийн хувьцааны 1,22%-ийг Хөгжлийн банкинд шилжүүлэн өгөх
2. Зээлийн хугацааг 8 жил болгон сунгаж төлбөрийн графикайг шинэчлэх

Дээрх 2 замын эхний хувилбар нь Засгийн газрын 2018 оны 245 тоот тогтоолоор хэрэгжих боломжгүй болсон тул Засгийн газрын 2017 оны 42 тоот тогтоолыг үндэслэн зээлийн үндсэн төлбөрийг эргэн төлөх хугацааг сунгах талаар Хөгжлийн банкт харилцан тохиролцож холбогдох тогтоол шийдвэрийг яаралтай гаргуулах шаардлагатай байна.

Гурав. Охин компаниудад олгож байгаа санхүүжилтийн талаар

“Эрдэнэс Монгол” ХХК-ийн дүрмийн 4.1.4.2-т үндсэн үйл ажиллагааны чиглэлийн нэг нь “хувьцааг нь эзэмшдэг хуулийн этгээдэд зээл олгох, хөрөнгө оруулах” гэж заасны дагуу хараат болон охин компаниудын төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, үйл ажиллагааны урсгал зардал болон хөрөнгийн түр дутагдлыг санхүүжүүлэх зорилгоор эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр хүүтэй зээлийн гэрээ байгуулан санхүүжилт олгож байна. Охин компаниудад олгож байгаа санхүүжилтийн зээлийн гэрээтэй танилцахад эргэн төлөлтийн хуваарь байхгүй байгаагаас гадна зээлийн барьцааг дараа оны болон ирээдүйн орлого гэж заасан боловч “Багануур” ХК, “Шивээ овоо” ХК-аас бусад охин компаниуд нь ямар нэгэн орлого олоогүй байгаа тул энэ заалт нь зээлийн гэрээний барьцаалбарын үндсэн шаардлагыг хангахгүй, найдваргүй авлага үүсгэх эрсдэлтэй байна. 2018 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар охин компаниудаас авах нийт 35,611.9 сая төгрөгийн үндсэн зээл болон хүүний авлагын үлдэгдэл байгаа бөгөөд үүний дотор зөвхөн “Мон-Атом” ХК-ийн хувьд гэхэд л 2012

оноос хойш олгосон 1,476.9 сая төгрөгийн үндсэн зээлийн, 456,4 сая төгрөгийн үндсэн ба нэмэгдүүлсэн хүү, нийт 1,933.3 сая төгрөгийн өр огт төлөгдөөгүй хуримтлагдаад байна.

Дээр дурдсан асуудлуудыг 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар дахин авч үзэхээр төлөвлөж байна.

2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

“Эрдэнэс Монгол” ХХК нь 2018 онд 72,673.4 сая төгрөгийн орлого бүрдүүлснийг нэр төрлөөр нь авч үзвэл Гашуун сухайт -Таван толгой чиглэлийн авто замын хураамжийн орлого 86.9%, менежментийн төлбөрийн орлого 9.2%, хүүний орлого 3.1%, Шивээ-Овоо уурхайн талбай ашигласны төлбөр 0.5%, бусад орлого 0.3%-ийг тус тус эзэлж байна.

2018 онд авто замаар 17.0 сая тонн нүүрс тээвэрлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 19.6 сая тонн нүүрс тээвэрлэснээр авто замын хураамжийн орлогын төлөвлөгөө болох 54,400.0 сая төгрөгөөс 19.8%-аар давуулан биелүүлж оны эцсийн гүйцэтгэлээр 65,184.8 сая төгрөгийн орлого олсон.

Засгийн газрын 2018 оны 8 дугаар сарын 8-ны өдрийн 245 дугаар тогтоолын дагуу “Эрдэнэс Таван толгой” ХК-ийн төрийн эзэмшлийн хувьцааг эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчээр Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрыг томилсноор 2019 онд тус компаниас менежментийн төлбөр авах боломжгүй болсон. Үүнээс шалтгаалан 2018 оны менежментийн төлбөрийн орлогын гүйцэтгэл буурч 6,917.6 сая төгрөг буюу 79.6%-ийн биелэлттэй гарсан байна.

Үйл ажиллагааны зардалд 2018 онд нийт 50,595.9 сая төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс 2018 оны гүйцэтгэлээр 42,539.1 сая төгрөг буюу 84.1%-ийн гүйцэтгэлтэй байна.

Гашуун сухайтын авто замтай холбоотой зардлын гүйцэтгэл нийт 35,094.7 сая төгрөг буюу 84.1%-тай байна. Үүнээс Хөгжлийн банкны зээлийн хүүнд 10,338.1 сая төгрөг, “Гашуун сухайт авто зам” ХХК-ийн үйл ажиллагааны зардалд 11,576.8 сая төгрөг, авто замын засвар, арчлалтын зардалд 13,179.8 сая төгрөг тус тус зарцуулсан.

Компани нь өөрийн үйл ажиллагааны зардлаа төлөвлөсөн хэмжээнээс 26.3%-аар хэмнэсэн ба нийт 6,673.3 тэрбум төгрөгийг зарцуулсан байна. Үүнээс цалин болон нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 2,821.2 сая төгрөг, оффисын түрээсийн зардал 625.5 сая төгрөг, албан томилолтын зардал 417.9 сая төгрөг, гэрээт ажлын зардал 330.1 сая төгрөг, хурал уулзалтын зардал 328.1 сая төгрөг байна. 2018 онд эрсдэлийн сангийн зардал 92.2%, дотоод албан томилолт 44.7%, мэдээлэл, зар сурталчигааны зардал 29.0%, тайлан, үйлчилгээний зардал 26.8%, оффисын түрээсийн зардал 23.6%-ийн тус хэмнэлттэй гарсан

байна. Азийн Хөгжлийн Банкны төслийн зардал 771.1 сая төгрөг буюу 59%-ийн гүйцэтгэлтэй байгаагаас дотоод санхүүжилтийн зардалд 196.4 сая төгрөг, зээлийн санхүүжилтийн зардалд 574.7 сая төгрөг тус тус зарцуулсан.

2018 онд 28,322.7 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан нь тус оны төлөвлөгөөнөөс 2.2 дахин өндөр үзүүлэлт байна. Компани Улсын төсөвт 6,736.9 сая төгрөгийн орлогын албан татварыг төвлөрүүлсэн байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

“Эрдэнэс Монгол” ХХК нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээлэл дээр бүтэн жилээр оруулах мэдээллийн хэсэгт “Эрдэнэс Монгол” ХХК-ийн 2018 оны худалдан авалтын төлөвлөгөөг оруулсан байна. 2018 оны хувьд худалдан авалтын төлөвлөгөөнд тусгагдсан 22,839.2 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 26 ажлаас 12 ажлын гэрээ байгуулагдаж эрх олгогдсон тухай гэрээт ажил тус бүрээр мэдээллийг оруулсан байна.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 83.3 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид “Эрдэнэс Монгол” ХХК-ийн 2018 оны санхүүгийн тайланд аудит хийхдээ АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Эрдэнэс Монгол” ХХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тусгасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидал АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтэд үндэслэсэн болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь “Эрдэнэс Монгол” ХХК-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 НӨАТ-ын ногдуулалттай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

2018 онд Охин компаниудад олгосон нийт 28,326.3 сая төгрөгийн санхүүжилтийг зээл хэлбэрээр хийж 1,116.2 сая төгрөгийн хүүгийн орлого бүртгэсэн боловч НӨАТ ногдуулаагүй байна. Энэ талаар “Эрдэнэс Монгол” ХХК-ийн дүрэмд хараат болон охин компаниудад зээл олгох эрхтэй тухай заасан гэж холбогдох ажилтнууд тайлбар өгч байгаа боловч Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.3.4-д “банкнаас бусад этгээд хадгаламж, зээлийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлнэ” гэсэн заалтын дагуу “Эрдэнэс Монгол” ХХК-ийн хараат ба охин компаниудад олгож байгаа санхүүжилтийн эргэн төлөлтийн хариуцлагыг нэмэгдүүлэх хөшүүрэг хэлбэрээр авч байгаа зээлийн хүүгийн орлого олох болон зээл олгох үйл ажиллагаа нь НӨАТ-ын тухай хуулийн 13.6.5 дахь заалтад хамаарах НӨАТ-аас чөлөөлөгдөх “урьдчилгаа зээл олгох үйлчилгээ” биш гэж үзэж байна.

3.1.2 Эрсдэл:

“Эрдэнэс Монгол” ХХК-ийн хараат болон охин компаниудаас 2018 онд төвлөрүүлсэн 1,116.3 сая төгрөгийн хүүний орлогод 111.6 сая төгрөгийн НӨАТ-ын татвар ноогдох эрсдэлтэй байна.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

НӨАТ-ын тухай хуулийн НӨАТ-аас чөлөөлөгдөх орлогын тухай хуулийн заалтын талаар эрх бүхий байгууллагаас лавлагаа, хуулийн заалтын тайлбар гаргуулж холбогдох арга хэмжээ авах.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зээл олгох үйлчилгээ нь Компанийн дүрэмд заасан үйл ажиллагаа тул зээлийн хүүд НӨАТ тооцож оногдуулахгүй гэж үзэж байна.

3.2 Шатахууны зарцуулалттай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Гүйцэтгэх захирлын тушаалаар Компанийн дэд захирлуудад сар бүр 0.5 сая төгрөгийн шатахууны лимит олгож байна. Дэд захирлуудад картаар олгосон 29.3 сая төгрөгийн шатахуун, томилолтоор ажилласан автомашинд олгосон 12.5 сая төгрөгийн нийт 41.8 сая төгрөгийн шатахууны зарцуулалтыг шатахуун зарцуулалтын нормоор тооцоогүй жолоочийн тооцооны хуудас хөтлөөгүй, автомашины банкны үлдэгдлийг баталгаажуулаагүй байна. Шатахууны зардлыг шууд худалдан авсан дүнгээр нь НӨАТ-ын худалдан авалтын баримтыг үндэслэн хүлээн зөвшөөрч байна.

3.2.2 Эрсдэл:

Хөрөнгийн зүй бус зарцуулалт гарах

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Шатахууны зарцуулалтыг автомашины шатахуун зарцуулалтын нормоор тооцон үлдэгдлийг баталгаажуулж байх. Жолоочийн тооцоо хөтөлж бодит зарцуулалтыг үндэслэн дэд захирлуудад шатахууны картын нөхөн дүүргэлт хийж байх

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийг мөрдөж ажиллана

3.3 Автомашины ашиглалтын тухай

3.3.1 Илрүүлэлт:

Компанийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй Nissan X-Trial маркийн 01-25 УБЛ улсын дугаартай 69,9 сая төгрөгийн өртөг бүхий автомашиныг гадны байгууллагад үнэ төлбөргүй ашиглуулж байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 26 дугаар зүйлд “Төрийн өмчит хуулийн этгээд нь өөрт олгогдсон эд хөрөнгийг энэ хуулиар тогтоосон журмын дагуу эзэмшиж ашиглана” гэж заасныг зөрчиж байна.

3.3.2 Эрсдэл:

Хөрөнгийн зүй бус ашиглалт үүсэх

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Шаардлагатай бол илүүдэлтэй байгаа автомашиныг гадны байгууллагад Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасны дагуу түрээсийн гэрээгээр ашиглуулах

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Автомашиныг өөрийн байгууллагад буцааж авчирсан.

3.4 Дуудлага худалдааны тухай

3.4.1. Илрүүлэлт:

Гашуун сухайтын авто замд ашиглагдаж байсан ашиглалтын хугацаа дуусаагүй, 48.5 сая төгрөгийн үлдэгдэл өртөгтэй 6 автомашиныг дуудлага худалдаагаар 22.5 сая төгрөгөөр зарж борлуулахдаа “Эрдэнэс Монгол” ХХК болон хараат болон охин компаниудын өмч хөрөнгө эзэмших ашиглан зарцуулах журам”-д заасан “Үлдэгдэл өртөгтэй тээврийн хэрэгслийг зарж борлуулахдаа тэ эврийн хэрэгслийн гэмтлийг хөндлөнгийн мэргэжлийн байгууллагаар тогтоолгоно, дуудлага худалдаа явуулах тухай Гүйцэтгэх захирлын тушаал гарснаас хойш 14 хоногийн дотор дуудлага худалдаа явуулах тухай зарыг хэвлэлд байршуулна” гэсэн заалтуудыг зөрчсөн.

3.4.2 Эрсдэл:

Төрийн өмчийн хөрөнгийг зүй бусаар ашиглалтаас хасах

3.4.3 Өгсөн зөвлөмж:

Төрийн өмчийг захиран зарцуулахдаа холбогдох хууль журмын заалтыг мөрдлөг болгон ажиллах

3.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Актлагдсан 6 автомашины зах зээлийн үнийг мэргэжлийн үнэлгээний байгууллагаар тогтоолгосон. Хойшид батлагдсан дүрэм журмыг мөрдөж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2018 оны 3 сарын 13-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.4.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан (төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2017 оны 12-р сарын 31	2018 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	11,871,985,311.00	13,758,484,101.38
1.1.2	Дансны авлага	3,710,715,421.60	6,740,612,757.66
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	387,662,778.04	73,101,542.30
1.1.4	Бусад авлага	25,120,167,224.88	28,301,809,150.92
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	31,241,809.52	26,939,471.20
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	1,710,259,306.49	1,830,333,077.54
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	11,655,950,999.64	
1.1.10			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	54,487,982,851.17	50,731,280,101.00
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	2,361,074,770.02	173,840,797,863.42
1.2.2	Биет бус хөрөнгө	157,150,747,655.71	447,684,457.82
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	9,128,695,451,467.00	9,128,796,451,467.00
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	51,155,535.95	301,409,685.04
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө		7,095,839.48
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	15,356,418,864.83	41,138,043,992.11
1.2.9			
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	9,303,614,848,293.51	9,344,531,483,304.87
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	9,358,102,831,144.68	9,395,262,763,405.87
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	1,293,272,588.26	2,476,574,094.92
2.1.1.2	Цалингийн өглөг	172,108,952.00	56,642,950.00
2.1.1.3	Татварын өр	281,521,552.60	1,744,958,363.49

“Эрдэнэс Монгол” ХХК-ийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

2.1.1.4	НДШ–ийн өглөг		
2.1.1.5	Богино хугацаат зээл		85,297,739,852.00
2.1.1.6	Хүүний өглөг	2,294,205,401.84	2,294,205,401.79
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг		
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	20,555,426.25	1,463,477.02
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	237,431,742.86	15,507,620,441.80
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)-нд хамаарах өр төлбөр		
	Богино хугацаат өр төлбөрийн дүн	4,299,095,663.81	107,379,204,581.02
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	186,938,320,406.59	105,181,996,984.93
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	67,195,150,944.29	61,442,454,485.29
2.1.2.5			
	Урт хугацаат өр төлбөрийн дүн	254,133,471,350.88	166,624,451,470.22
2.2	Өр төлбөрийн нийт дүн	258,432,567,014.69	274,003,656,051.24
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:-төрийн	100,000,000.00	100,000,000.00
2.3.2	- хувийн		3,000,000.00
2.3.3	- хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	9,128,184,251,467.00	9,128,184,251,467.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(28,613,987,337.01)	(7,028,144,112.37)
2.3.10			
2.3.11	Эздийн өмчийн дүн	9,099,670,264,129.99	9,121,259,107,354.63
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	9,358,102,831,144.68	9,395,262,763,405.87

4.2 Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан (төгрөгөөр)

№	Үзүүлэлт	2017 оны 12-р сарын 31	2018 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	62,533,964,803.43	72,673,389,358.58
2	Борлуулалтын өртөг	(16,205,308,470.59)	(24,756,602,935.43)
3	Нийт ашиг(алдагдал)	46,328,656,332.84	47,916,786,423.15
4	Түрээсийн орлого		
5	Хүүгийн орлого	1,711,950,887.01	2,346,860,601.24
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого		
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	10,837,383,332.06	8,454,045,662.02
11	Санхүүгийн зардал	11,484,303,105.22	11,631,805,066.98
12	Бусад зардал		
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	321,718,516.07	(1,533,400,619.04)
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(76,282,928.03)	(64,171,877.64)
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз(гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)	(193,484,968.48)	(257,498,715.52)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	25,770,871,402.13	28,322,725,083.19
19	Орлогын татварын зардал	5,722,340,769.10	6,736,881,858.55
20	Татварын дараах ашиг (алдагдал)	20,048,530,633.03	21,585,843,224.64
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	20,048,530,633.03	21,585,843,224.64
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
23.3	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн		
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

“Эрдэнэс Монгол” ХХК-ийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

4.3 Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан (төгрөгөөр)

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин нэлгээний нэмэгдэл	Гадаад валютын гөрүүлэлтийн нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2016 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	100,000,000.00						-48,779,895,160.94	-48,679,895,160.94
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга							117,377,190.90	117,377,190.90
3	Залруулсан үлдэгдэл	100,000,000.00						-48,662,517,970.04	-48,562,517,970.04
4	Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)							20,048,530,633.03	20,048,530,633.03
5	Бусад дэлгэрэнгүй орлого								
6	Өмчид гарсан өөрчлөлт								
7	Зарласан ногдол ашиг								
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	9,128,184,251,467.00							9,128,184,251,467.00
9	2017 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	9,128,284,251,467.00						-28,613,987,337.01	9,099,670,264,129.99
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга								
11	Залруулсан үлдэгдэл								
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)							21,585,843,224.64	21,585,843,224.64
13	Бусад дэлгэрэнгүй орлого								
14	Өмчид гарсан өөрчлөлт								
15	Зарласан ногдол ашиг								
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	3,000,000.00							3,000,000.00
17	2018 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	9,128,287,251,467.00						-7,028,144,112.37	9,121,259,107,354.63

4.4 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан (төгрөгөөр)

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	63,033,732,729.02	68,760,462,564.55
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	62,805,190,518.47	68,704,149,945.55
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	0.00	0.00
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	9,106,140.00	25,918,408.00
1.1.4	Буцаан авсан албан татвар		
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого		
1.1.6	Бусад мөнгөн орлого	219,436,070.55	30,394,211.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	62,312,073,853.09	84,898,511,023.94
1.2.1	Ажиллагчдад төлсөн	4,605,102,497.37	3,833,255,973.72
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	932,779,002.83	752,252,983.59
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	171,060,044.70	164,985,143.55
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	0.00	0.00
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	96,279,158.00	116,994,548.32
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн	21,160,596,942.90	10,484,414,837.22
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	11,243,274,263.88	10,447,900,185.18
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	0.00	0.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	24,102,981,943.41	59,011,225,512.36
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	721,658,875.93	16,138,048,459.39
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	2,246,976,322.10	1,132,914,621.70
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	0.00	22,470,350.00
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	0.00	0.00
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	0.00	0.00
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	0.00	0.00
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	1,435,588,976.15	63,418,408.82
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	811,387,345.95	1,047,025,862.88
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг	0.00	0.00
2.1.8		0.00	0.00

“Эрдэнэс Монгол” ХХК-ийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	2,128,166,463.89	2,921,401,869.21
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,963,532,734.00	2,730,028,530.93
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	164,633,729.89	191,373,338.28
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	0.00	0.00
2.2.6			
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	118,809,858.21	1,788,487,247.51
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	3,137,638,043.51	19,813,034,497.28
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	3,142,072,279.99	19,726,072,341.66
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	0.00	0.00
3.1.3	Төрөл бүрийн хандив	0.00	0.00
3.1.4		4,434,236.48	86,962,155.62
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,252,263,102.28	0.00
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	1,252,263,102.28	0.00
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	0.00	0.00
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	0.00	0.00
3.2.4	Төлсөн ногдол ашиг	0.00	0.00
3.2.5		0.00	0.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,885,374,941.23	19,813,034,497.28
4	Валютын ханшийн зөрүү	0.00	0.00
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	2,725,843,675.37	1,886,498,790.38
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	9,146,141,635.63	11,871,985,311.00
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	11,871,985,311.00	13,758,484,101.38

5. Хавсралт

5.1 Аудитоор илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл

Аудитын нэр:	"Эрдэнэс Монгол" ХХК 2018 оны санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:
2019.03.13		САГ-2019/59/СТА-ТӨҮГ
Шалгагдсан байгууллагын нэр:		Сая төгрөгөөр
	"Эрдэнэс Монгол" ХХК	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Үйлчлүүлэгч байгууллагын талаас алдаа, зөрчилтэй асуудлыг хариуцах хүний	
				Албан тушаал	Овог нэр
А	1	2	3	4	5
1	2018 онд Охин компаниудад олгосон нийт 28,326.3 сая төгрөгийн санхүүжилтийг зээл хэлбэрээр хийж 1,116.3 сая төгрөгийн хүүний орлогод 111.6 сая төгрөгийн НӨАТ ногдуулаагүй	111.6	Зөвлөмж өгөх	Санхүү эрхэлсэн дэд захирал Ерөнхий нягтлан бодогч	Г.Ганболд Д.Отгонцэцэг
2	Компанийн дэд захирлуудад лимитийн дагуу олгосон нийт 29,3 сая, томилолтоор ажилласан автомашинд олгосон 12,5 сая төгрөгийн нийт 41,8 сая төгрөгийн шатахуун зарцуулалтыг нормоор тооцоогүй, жолоочийн тооцооны хуудас үйлдээгүй банкны үлдэгдлийг баталгаажуулаагүй байна. Шатахууны зардлыг шууд худалдан авсан дүнгээр хүлээн зөвшөөрч байна.	41.8	Зөвлөмж өгөх	Санхүү эрхэлсэн дэд захирал Ерөнхий нягтлан бодогч	Г.Ганболд Д.Отгонцэцэг
3	Гашуун сухайтын авто замд ашиглаж байсан ашиглалтын хугацаа дуусаагүй 48,5 сая төгрөгийн үлдэгдэл өртөг бүхий суудлын 6 автомашины гэмтлийг мэргэжлийн байгууллагаар			Санхүү эрхэлсэн дэд захирал	Г.Ганболд

“Эрдэнэс Монгол” ХХК-ийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

	тогтоолголгүйгээр 22,5 сая төгрөгөөр дуудлага худалдаагаар зарж борлуулсан. Дуудлага худалдааг явуулах журмын заалт зөрчсөн.	48.5	Зөвлөмж өгөх	Ерөнхий нягтлан бодогч	Д.Отгонцэцэг
4	Компанийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй Nissan X-Trial маркийн 01-25 УБЛ улсын дугаартай 69,900.0 мянган төгрөгийн өртөг бүхий автомашиныг гадны байгууллагад үнэ төлбөргүй ашиглуулдаг	69.9	Зөвлөмж өгөх	Санхүү эрхэлсэн дэд захирал Ерөнхий нягтлан бодогч	Г.Ганболд Д.Отгонцэцэг
	Нийт дүн	271.8			

